

## ЯПОН УЛСААС МАНАЙ ОРОНД ҮЗҮҮЛЖ БУЙ ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН АСУУДАЛ

С.Азжаргал<sup>1,2</sup>

<sup>1</sup> Шинжлэх ухааны Академи, Монгол улс

<sup>2</sup> МУИС, Монгол улс

---

Хүлээн авсан: 2018.03.05, Хянасан: 2018.03.27, Хэвлэгдсэн: 2018.04.03

---

### ХУРААНГУЙ

Япон улс нь 1954 оноос эхлэн хөгжиж буй орнуудад үзүүлдэг хөгжлийн албан ёсны тусламжаараа дамжуулан өөрийн улс болон олон улсад тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулсаар ирсэн билээ. Монгол, Япон хоёр орны харилцаа 1990 оноос шинэ шатанд өргөжин гүнзгийрч, 1997 оноос “Иж бүрэн түншлэлийн түвшин”-д, 2010 оноос “Стратегийн түншлэлийн түвшин”-д дэвшиж, 2015 оноос “Эдийн засгийн түншлэлийн түвшин”-д хүрээд байна.

**Түлхүүр үг:** Хөгжлийн албан ёсны тусламж; Япон улс; буцалтгүй тусламж; хөнгөлөлттэй зээл; хамтын ажиллагаа;

### ОРШИЛ

Одоогоос 30-аад жилийн өмнө Монгол улсын эдийн засаг ЗХУ-аас бүрэн хамааралтай байж байгаад, зах зээлд шилжихэд дэлгүүрийн лангуунд л гэхэд давснаас өөр зүйлгүй байсан гэдэг. Харин 1990-ээд оны ардчиллын дараагаар манай эдийн засаг зах зээлийн эдийн засаг руу аажмаар шилжих явцад олон улсын хөгжлийн институцуудын тусламж, хөнгөлөлттэй зээл ялангуяа Япон улсаас тусламж, хөнгөлөлттэй зээлийг эрчимтэй

авах болсон бөгөөд юун түрүүнд хөдөө аж ахуй, эрчим хүч, нүүрс олборлолт, түлш шатахуун худалдан авахад зарцуулж иржээ. Өнгөрсөн хуацаанд Монгол улс шилжилтийн хүнд хэцүү цаг үеийг давж хөгжлийн шинэ шатандаа ирээд байгаа билээ. Энэхүү дэвшилд Япон улс голлох үүргийг гүйцэтгэж ирсэн бөгөөд 1990 оноос өнөөг хүртэл гадны орнуудаас манай улсад үзүүлж буй тусламжаар тэргүүлсээр байгаа юм.

---

\*corresponding author: [azushka1130@gmail.com](mailto:azushka1130@gmail.com)



The Author(s). 2018 Open access This article is distributed under the terms of the Creative Commons Attribution 4.0 International License (<http://creativecommons.org/licenses/by/4.0>), which permits unrestricted use, distribution, and reproduction in any medium, provided you give appropriate credit to the original author(s) and the source, provide a link to the Creative Commons license, and indicate if changes were made.

## МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ

Энэхүү өгүүлэлд Япон улсаас манай улсад үзүүлж буй хөгжлийн албан ёсны тусламжийн талаар судлан, дэлхийн бусад улсуудаас манай улсад үзүүлж буй зээл тусламжийн байдалтай харьцуулан дүгнэхийг зорилоо.

### **Хөгжлийн албан ёсны тусламж тогтвортой хөгжилд чиглэж байгаа нь**

1992 онд Бразилийн Рео-де-Жанеро хотод болсон “Хөгжил ба орчин” сэдэвт НҮБ-ын чуулганаас дэлхийн хөгжлийн шинэ чиг хандлагатай уялдан улс орон бүрийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, “Байгаль орчин, нийгэм, эдийн засгийг хэрхэн зөв зохистой хослуулан хөгжих вэ” гэдэг асуултыг дэлхий нийтийн хэмжээнд гаргаж тавьснаар “Тогтвортой хөгжил” гэх ойлголт түгэн дэлгэрчээ. Иоханнесбургийн тунхаглал (2002) болон Риогийн тунхаглал (1992, 2012)-д олон улсын хамтын ажиллагаа өргөжүүлж дэлхий нийтээр тогтвортой хөгжилд хүрэх зорилт тавьсан бөгөөд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг сайжруулахад “Засгийн газрын байгууллага, орон нутгийн удирдлага, хувийн хэвшил, иргэд, дотоод гадаадын хөрөнгө оруулагчдын хамтын ажиллагаа, харилцан түншлэлийг хөгжүүлэх нь чухал хэмээн заасан байдаг[1]. Энэхүү тогтвортой хөгжлийг хангах зорилгоор Монгол, Япон улс тууштай хамтран ажилласаар ирлээ. Япон улсын Засгийн газраас дэлхийн өндөр хөгжилтэй, тэргүүлэгч орон болохын хувьд дэлхий нийтийн хөгжилд хувь нэмэр оруулахыг зорьж 1954 оноос эхлэн Засгийн газраас хэрэгжүүлж буй Хөгжлийн албан ёсны тусламж Official Development Assistance (ODA)-ийг хөгжиж буй орнуудад үзүүлж ирсэн. 2015 онд хөгжиж буй орнуудад үзүүлсэн Япон улсын Засгийн газрын Хөгжлийн албан ёсны тусламжийн нийт хэмжээ 10 гаруй тэрбум ам.долларт хүрсэн үзүүлэлтээр дэлхийн хэмжээнд 4

дүгээр байр эзэлж байна[2]. Монгол Япон хоёр улсын хооронд 1972 онд дипломат харилцаа тогтоосноос хойш анх удаа буюу 1977 онд “Говь” ноолуурын үйлдвэр байгуулах буцалтгүй тусламж үзүүлснээр Япон улсаас манай улсад үзүүлэх зээл, тусламжийн цуваа эхэлсэн гэж үздэг бөгөөд түүнээс хойш өдийг хүртэл 240 орчим тэрбум иений 400 гаруй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлээд байна. Манай улсад үзүүлсэн тусламж нь: хоёр улсын өндөр дээд хэмжээний уулзалтын баримт бичгүүд, Засгийн газрын хамтарсан мэдэгдэлд туссаны дагуу манай улсын хувьд эдийн засгийн бэрхшээлийг даван туулах, байгаль орчныг хамгаалах, ядуурлыг бууруулах, хүний хөгжлийг ахиулах зэрэгт чиглэгдсээр ирсэн[3]. 1989 оныг хүртэл Япон улсаас манай улсад үзүүлж буй зээл тусламж нь албан ёсны буцалтгүй тусламж болон соёлын харилцаагаар хязгаарлагдаж байсан бол Монгол улс ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засагт шилжсэнээр эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих замаар ядуурлыг бууруулахад чиглэгдсэн зорилтыг дэвшүүлж хамтран ажиллах болсон байна.

Хөгжлийн албан ёсны тусламжаа иений хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, техникийн хамтын ажиллагаа гэсэн хэлбэрээр олгож иржээ. 1990 онд иений хөнгөлөлттэй зээлийг анх удаа олгож дэд бүтцийн салбарт цахилгаан станц, харилцаа, холбоо, тээвэрт, хөдөө аж ахуйн салбарт мах, сүү боловсруулах үйлдвэр, үр тариа хадгалах байгууламж, хүнсний тусламж, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж нийлүүлэх зэргээр тусламж үзүүлсэн нь зах зээлийн хүнд хэцүү үед манай улсыг тухайн хямралаас гарах боломжийг нээж өгсөн юм. Тухайлбал манай улсад томоохон бүтээн байгуулалт болж буй “Улаанбаатар хотод олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”, “Цэций салхин станц

барьж байгуулах төсөл”, “Улаанбаатар хотын дулааны 4-р цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл”, “Инженер, технологийн дээд боловсрол төсөл”, 1000 инженер зэрэг төслүүдийг дурьдаж болно.

Түүнчлэн Япон улсын Засгийн газраас манай улсад 1990 оноос хэрэгжүүлж эхэлсэн “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр” нь хөгжиж буй орнуудын орон нутгийн засаг захиргаа болон боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд гардан хэрэгжүүлдэг хамтын ажиллагааны төсөл юм. Уг хөтөлбөрөөр эрүүл мэндийг хамгаалах (эмнэлгийн барилга барих, тоног төхөөрөмж нийлүүлэх г.м), ерөнхий боловсролыг дэмжих (ерөнхий боловсролын сургуулийн барилгын засвар, тоног төхөөрөмж нийлүүлэх гэх мэт дэд бүтцийг шийдвэрлэх), ядуурлыг бууруулах (Зудын болон ой сав, тал газарт гарах гамшгийг даван туулах чадавхийг бэхжүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх г.м), олон нийтийн аж ахуйг сайжруулах (эмэгтэйчүүдийг чадваржуулах мэргэжлийн сургалтанд хамруулах г.м) байгаль орчныг хамгаалах (хог хаягдлыг бууруулах, ус, намгархаг газрыг хамгаалах гэх мэт)-д чиглэгдсэн ажлууд түлхүү хийгдэж ирсэн байна. Техникийн хамтын ажиллагааны хүрээнд хүний нөөцийг чадавхжуулах, чадварлаг төрийн албан хаагч, мэргэжилтнүүдийг Япон улсын их, дээд сургууль суралцуулах, хоёр улсын эрдэмтэн судлаачдыг оролцуулсан хамтарсан судалгааны төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх зэрэг ажлууд хийгдсээр байна. Жишээлбэл: 2001 оноос эхэлсэн “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр” (The Project for Human Resource Development Scholarship) -ийг энд дурьдаж болно.

Өвсний үндэс хөтөлбөрийн буцалтгүй тусламжийн хүрээнд 1990 оноос хойш 500 гаруй төсөл амжилттай хэрэгжиж дууссан байна.

Япон улсын Засгийн газар манай улсад үзүүлэх 5 жилийн “Тусламжийн тусгай

хөтөлбөр”-ийг 2004 оны 11 дүгээр сард баталж, улмаар дараах 4 салбарт тусламж дэмжлэгээ төвлөрүүлэхээр тодорхойлсон байдаг. Үүнд:

- Зах зээлийн эдийн засгийн тогтолцоог хөхиүлэн дэмжих, боловсон хүчин бэлтгэхэд үзүүлэх тусламж;
- Хөдөө орон нутгийг хөгжүүлэхэд чиглэсэн тусламж;
- Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн тусламж;
- Эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн дэд бүтцийг буй болгоход үзүүлэх тусламж зэргийг гол үндсэн чиглэлээ болгосон байна[4].

Энэ хүрээнд 2005-2016 оны хооронд Улаанбаатар хотын ус хангамжийн байгууламжийг сайжруулах төсөл, Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр (JDS) (2 төсөл), Зүүн бүсийн гол авто замыг барих болон зам барилгын тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, Дархан хотын ус хангамжийн байгууламжийг сайжруулах төсөл гэх мэт нийт 425 гаруй сая иений төсөл, хөтөлбөрүүдийг шат дараатайгаар амжилттай хэрэгжүүлсэн.

Манай улсын уул уурхайн нөөц баялагт түшиглэх бодлогын нөлөө, уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт эрчимтэй нэмэгдсэний үр дүнд эдийн засгийн өсөлт огцом дээшилж 2011 онд 17%, 2012 онд 12%-ийн өсөлт үзүүлж байв[5].

Манай улс глобал индексийн үзүүлэлтүүдээр 2006 онд буурай хөгжилтэй орноос дундаас доогуур хөгжилтэй оронд бичигдэж байсан бол 2012 оноос дундаас дээгүүр хөгжилтэй орны жагсаалтад бичигдэх болов. Ингэснээр хөгжлийн хөнгөлөлттэй том зээлүүдийг авах боломж ихээр нэмэгдэв.

Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж эдийн засаг өссөн ч ядуурлыг бууруулах, үндэсний аюулгүй байдлыг хангах, ажлын байр бий болгох, шинэ техник технологи нэвтрүүлэх, хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг

хамгаалах чиглэлээр төдийлөн дорвитой ахиц гараагүй байна[6].

Иймээс Японы Засгийн газраас манай улсад үзүүлэх тусламжийн чиглэлийг 2012 онд дахин шинэчлэн тодотгож:

- Уул уурхайн салбарын тогтвортой хөгжил, баялагаас орох орлогын зохистой удирдлага, засаглалыг бэхжүүлэх;
- Бүх нийтэд өгөөжтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих;
- Улаанбаатар хотын чадавхийг бэхжүүлэх гэсэн 3 чиглэлээр хамтран ажиллахаар болжээ.

Энэ хүрээнд байгаль орчны салбарт уул уурхай хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, аж үйлдвэрийг төрөлжүүлэх зорилго бүхий бичил, жижиг, дунд аж ахуй нэгжүүдэд түшиглэсэн ажлын байр бий болгох, үйл ажиллагааг дэмжих, мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйл ажиллагааг дэмжих, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хангамжийг сайжруулах, Улаанбаатар хотын агаарын бохирдол, хог хаягдал, зам тээврийн асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааг дэмжих чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн зээл тусламж олгох болов[7]. Дээрх тусламжийн чиглэлүүдээс Улаанбаатар хотын чадавхийг бэхжүүлэх, дэд бүтцийг сайжруулах, хот төлөвлөлт, удирдлагын чадавхийг бэхжүүлэхэд үзүүлэх дэмжлэгийг тэргүүлэх чиглэл байхаар заажээ[8].

2013 онд байгуулагдсан “Монгол Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр 2013-2017”-т хөрөнгө оруулалт, бизнесийн орчинг бүрдүүлэх, байгаль орчны салбарт хэрэгжүүлэх хамтын ажиллагааг иж бүрнээр авч үзэн, манай орны байгаль орчин, худалдаа эдийн засгийн салбарт тулгараад буй асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллахаар тусгажээ.

Энэхүү хөтөлбөрийн эдийн засгийн хамтын ажиллагааны салбарт Монгол Японы стратегийн түншлэлийн зарчмууд, Монгол улсын тэргүүлэх чиглэл, Япон

улсын засгийн газраас монголд үзүүлэх тусламжийн чиглэлийн дагуу төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, Тухайлбал:

**Байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр:** Нүүрстөрөгч багатай үйлдвэрлэлийн төсөл хөтөлбөр, хагас коксжсон шахмал түлшний үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүчний нөөц, ашиглалт, цэвэр бохир усны системийг сайжруулах, гамшгаас сэргийлэх, авран хамгаалах чадавхийг дээшлүүлэх, цөлжилттэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах;

**Боловсон хүчин бэлтгэх чиглэлээр:** Инженер, техникийн дээд боловсрол олгох их сургуулийн чадавхийг бэхжүүлэх, аж үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг Япон улсад бэлтгэх, сургалтын эмнэлэг байгуулах, анагаах ухааны боловсон хүчнийг Японд бэлтгэх;

**Дэд бүтцийн хөгжил, бүтээн байгуулалтын чиглэлээр:** Олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих, дулааны IV цахилгаан станцын үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, Улаанбаатарт метро, гүүрэн гарц байгуулах, гэр хорооллын гудамж төсөл, сум хөгжүүлэх төсөлд хамтран ажиллах, экспортын зээлийн шугамын хүрээнд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, Дарханы нефть боловсруулах үйлдвэр байгуулах, сансрын технологийн төсөлд хамтран ажиллах, нүүрс боловсруулах, бага дунд сургуулийн орчныг сайжруулах, жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх, мах сүү боловсруулах, усалгаатай газар тариалан хөгжүүлэх зэрэг хөдөө аж ахуйн салбарт техникийн дэмжлэг үзүүлэх, аж үйлдвэрийн цогцолборын талаар мэдээлэл солилцох, хувийн хэвшлийн салбарыг мэдээллээр хангах зэрэг хамтын ажиллагааг дэмжих заалтуудыг тусгажээ[9].

Өвсний үндэс хөтөлбөрийн иений хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Японы Засгийн газраас манай улсын уул уурхайн салбараас хэт хамааралтай эдийн засгийн тогтолцоог өөрчлөхийн тулд аж үйлдвэрийг төрөлжүүлж, жижиг дунд бизнес эрхлэгчид, экспортын үйлдвэрлэлийг

дэмжих зорилгоор 2005, 2010 онд “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих-Байгаль орчныг хамгаалах” нийт 8 тэрбум иений 2 үе шаттай зээлийг олгосон бөгөөд үүний үр дүнд эхний шатны зээлээр 145 компанид санхүүжилтийн зээл олгогдож, 1330 ажлын байрыг шинээр бий болгож чаджээ. Түүнчлэн 2-р шатны төслөөр нийт зээлийн төсвийн 80 гаруй хувь нь бизнес эрхлэгчдэд хэдийнээ олгогдоод байна[10]. Хоёрдугаар шатны хүрээнд 5 тэрбум иен буюу ойролцоогоор 60 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийг 40 жилийн хугацаатай, үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 10 жил, жилийн 0,6 хувийн хүүтэй авахаар яриа хэлэлцээр хийгдсэн бөгөөд нийт зээлийн их үүсвэрээс 45 сая ам.долларыг жижиг дунд үйлдвэрийг дэмжих зориулалтаар 10 сая ам.долларыг байгаль орчныг хамгаалах, үүний дотор Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад зориулахаар төлөвлөжээ.

ЖДҮ-ийг хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдлийг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг төдийгүй орлогын тэгш бус хуваарилалтыг бууруулах, нийгмийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх, хувийн секторын хөгжлийг хангахад чухал хувь нэмэр үзүүлдэг байна.

2015 онд Монгол улсын Засгийн газар Япон улсын Засгийн газар хоорондын “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” байгуулагдаж, улмаар 2016 оноос хэрэгжиж эхлээд байна. Уг хэлэлцээрийг байгуулснаар манай улсын жилийн нийт экспорт 0.36 орчим хувиар өсөх бол Япон улсад хийх нийт экспорт жилийн 4.9-5.5 орчим хувь өсөх тооцоо бий гэсэн судалгаа байна[11].

Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр нь урт хугацаандаа Монгол Улсын эдийн засгийг ирээдүйд авч явах шинэ залуу салбаруудыг хөгжүүлэх, улсын нийт экспортыг нэмэгдүүлэхэд чиглэж буйг зарим эдийн засагч тодотгож байгаа юм. Хоёр орны эдийн засгийн түншлэлийн

хэлэлцээрийн 15 дугаар зүйлд тулгуурлан хамтын ажиллагаагаа дараах салбаруудад илүү өгөөжтэй, үр ашигтай хэрэгжүүлэхээр зорьжээ. Үүнд:

- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон загасны аж ахуй
- Аж үйлдвэрлэл
- Жижиг болон дунд үйлдвэрлэл
- Худалдаа болон хөрөнгө оруулалт
- Дэд бүтэц, барилга, хот байгуулалт
- Шинжлэх ухаан, технологи болон оюуны өмч
- Санхүүгийн үйлчилгээ
- Боловсрол болон хүний нөөцийн хөгжил
- Аялал жуулчлал
- Байгаль орчин
- Уул уурхай болон эрчим хүч
- Эрүүл мэнд
- Өрсөлдөөн
- Мэдээлэл, харилцаа холбооны технологи
- Хоёр улсын Засгийн газар хооронд харилцсан тохиролцсон бусад салбарыг хамааруулсан байна.


Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн төсөлд гадаад зээл, тусламжийн хүрээнд нийт 117 төсөл хөтөлбөрийг 857.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд үүнээс гадаад зээлийн 74 төсөл хөтөлбөрийг 723.1 тэрбум төгрөгөөр, буцалтгүй тусламжийн 43 төсөл, хөтөлбөрийг 134.6 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр тусгасан бөгөөд эдгээр хөнгөлөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрийг авч үзвэл БНХАУ-ын Эксим банкны санхүүжилт нийт санхүүжилтийн 34%, Японы Засгийн Газар болон Жайкагийн санхүүжилт 25%, Азийн хөгжлийн банкны санхүүжилт 21%-ийг тус тус эзэлж байна[12]. Манай улсад үзүүлж буй зээл, тусламжийн санхүүжилтийн хэмжээгээр БНХАУ-ын Засгийн газар болон түүний харьяа байгууллагууд тэргүүлж, Япон улс, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн банк, Бүгд Найрамдах Солонгос улс удаалж байна.

Хүснэгт 1. Гадаадын зээл, тусламж 2017 оны байдлаар (төгрөгөөр)

№	Санхүүжүүлэгч улс	Япон	Хятад	БНСУ	Герман	Кувейт	Европын холбоо	Энэтхэг	Унгар	Польш
1	Буцалтгүй тусламж	782.8 сая	26.3 тэрбум	15.4 тэрбум	5.8 тэрбум	15.1 тэрбум	10.5 тэрбум	-	-	-
2	Хөнгөлөлттэй зээл	199.9 тэрбум	254.9 тэрбум	25.6 тэрбум	9.3 тэрбум	-	-	15.6 тэрбум	5.7 тэрбум	1.1 тэрбум

Япон улсын Засгийн газраас 1991-2013 оны хооронд манай улсад 102.3 тэрбум иений буцалтгүй тусламж, 77.3 тэрбум иений хөнгөлөлттэй зээл, 36.5 тэрбум иений техник хамтын ажиллагааны тусламж үзүүлсэн нь ойролцоогоор 2.1 их наяд төгрөг буюу 850 сая.ам доллартай тэнцэхүйц хөрөнгө оруулалт болж байгаа юм. 2017 онд манай улс Олон улсын валютын сантай “Өргөгтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжүүлэх тохиролцоонд хүрснээр Япон улсаас Монгол улсад үзүүлэх “Төсөв, нийгэм эдийн засгийн шинэчлэлийн хөгжлийн бодлогын зээл”-ийн нот бичигт

хоёр улс гарын үсэг зурж, манай улсад 3 жилийн хугацаатай 850 сая.ам доллар хүртэлх иений хөнгөлөлттэй зээл олгохоор болсон байна. Үүний эхний 32 тэрбум иен буюу 283.3 сая ам.доллартай тэнцэх зээлийг жилийн 0.8%-ийн хүүтэйгээр 20 жилийн хугацаатай олгоод байна[13]. 1991-2013 оны хооронд буюу 22 жилийн хугацаанд олгосон нийт зээл, тусламжийн хэмжээтэй тэнцэхүйц зээлийг гуравхан жилийн дотор олгохоор болж байгаа нь Япон улс манай улсын хөгжил дэвшилд томоохон дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэж байгаа нь харагдаж байна.




Зураг 1. Гадаадын зээл, тусламжийн санхүүжилт 2017 оны байдлаар (салбараар)

Гадаадын зээл, тусламжийн төслүүдийн тоо болон санхүүжилтийн хэмжээг харьцуулж үзвэл Япон улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй нэг төслийн дундаж санхүүжилт хамгийн их буюу ойролцоогоор 26 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 90 орчим хувь нь дэд бүтэц,

10 орчим хувь нь боловсролын салбарт чиглэгдэж байна[14].

1991-2017 оны хооронд гадны зарим улсуудаас манай улсад үзүүлсэн зээл, тусламжийн хэмжээг харьцуулан харуулбал дараах үзүүлэлттэй байна.



Зураг 2. Манай оронд үзүүлж буй гадаадын буцалтгүй тусламж /1991-2017/



Зураг 3. Манай оронд үзүүлж буй гадаадын хөнгөлөлттэй зээл

## ДУГНЭЛТ

Япон улсын хөгжлийн албан ёсны тусламж Монгол улсын 21 аймаг 329 суманд хүрч, хүн ам, байгаль орчин, уул уурхай, хөдөө аж ахуй зэрэг бүхий л салбаруудад өөрийн үр өгөөжийг өгч, эдийн засгийн өсөлтөд үнэтэй хувь нэмэр оруулсаар байна.

Монгол улсын нийт төсвийн 20% нь гадаадын хөрөнгө оруулалтын зээлийн өрөнд явдаг гэсэн судалгаа байдаг. Тэгэхээр бид цаашид гадны хөрөнгө оруулалтаар орж ирж буй зээл тусламжийг үр ашигтай зарцуулж, эдийн засгийн өгөөжтэй бүтээн байгуулалтыг хийх, түргэн хугацаанд хөгжих боломжтой салбаруудад түлхүү хөрөнгө оруулалт хийх нь туйлын чухал болоод байна. Япон улс Монгол улсын эдийн засгийн хөгжлийг дагаад зөвхөн нэг талын эдийн засгийн туслалцааны

шатнаас харилцан ашигтай, бие биенээ нөхсөн эдийн засгийн харилцааг илүүд үзэх болсон. Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд үзүүлж буй хөгжлийн албан ёсны тусламжийг илүү үр өгөөжтэй ашиглах, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн харилцан хамаарлыг зохицуулах, Монгол улсын цаашдын хөгжилд нэн шаардлагатай богино хугацааны төсөл хөтөлбөрүүдийг илүү олноор нь хэрэгжүүлэх ялангуяа хувийн хэвшил жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллах нь зүйтэй юм.

Япон улс манай улсын хувьд “Хандивлагч” биш “Түнш орон” болж Монгол улсын хэрэгцээнд тулгуурласан хөгжлийн төлөөх үйл ажиллагааг цаашид ч идэвхтэй дэмжиж хамтран ажиллахад бэлэн байгаа болов уу.

## НОМ ЗҮЙ

1. Д.Дагвадорж. “Тогтвортой хөгжлийн боловсрол” УБ. 2004, 25-р тал
2. <http://www.eastasiaforum.org/2016/07/21/japanese-foreign-aid-whats-in-it-for-japan/>
3. XXI зууны Монгол Японы стратегийн түншлэл: Байгаль орчин, эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагаа” УБ., 2016, 81-р тал
4. Japan’s Assistance to Mongolia Embassy of Japan
5. XXI зууны Монгол Японы стратегийн түншлэл: Байгаль орчин, эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагаа” УБ., 2016, 29-р тал
6. НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ 2012-2016
7. Япон улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Т.Шимизүтэй хийсэн ярилцлага
8. “Монгол, Японы Стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр” /2013-2017/
9. <http://www.mn.emb-japan.go.jp>
10. Монгол банк. Жижиг дунд үйлдвэрлэлийн түүвэр судалгаа 2017
11. <http://www.ubinfo.mn>
12. Монгол улсын 2017 оны нэгдсэн төсвийн танилцуулга 2016
13. <https://mof.gov.mn/article/entry/article-2018-02-21-01>
14. [www.montsame.mn](http://www.montsame.mn)



## ISSUES OF JAPAN'S ASSISTANCE AND SUPPORT FOR MONGOLIA

*Azjargal S.<sup>1,2</sup>*

<sup>1</sup> *Mongolian Academy of Sciences, Mongolia*

<sup>2</sup> *National University of Mongolia, Mongolia*  
*corresponding author; e-mail: azushka1130@gmail.com*

**Abstract:** Through assistance to developing countries (Official Development Assistance (ODA)), Japan has contributed to the resolution of many evolving challenges which Japan and international community face. Japan's assistance to Mongolia is implemented from a viewpoint that economic development and humanitarian assistance in Mongolia will contribute to peace and prosperity in the region and the world. When Mongolia moved towards systematic transformation in 1990, prospects for sharing values such as freedom, democracy and market economy brightened. Japan started extensive bilateral assistance hoping that the success of systematic transformation and economic development in Mongolia would contribute to peace and stability in Asia and the world and that Mongolia would become a friendly nation of Japan. The relation between Mongolia and Japan have become expanding to a new level from 1990, and become "Comprehensive partnership level" from 1997, progressed to "Strategic partnership level" from 2010 and "Economic partnership" cooperation level has come from 2015.

**Keywords:** *Official Development Assistance; ODA; Japan; grant aid; loan aid; technical cooperation;*